

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДАА-2022/04/НА-СА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дархан-Уул аймаг

2022 он

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч:
Ш.Мөнхбаяр

Утас: 70378845 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АТМЭ Дархан-Уул аймаг
Дархан сум 14 р.Сэт
Телефон: 7777-0000, Саян: 8000 2000000
E-mail: darhan@aud.gov.mn

ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Т.ТУЛГАА ТАНАА

2020.02.01 № 04
ТАНАА 100.00



АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Торийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгөтөмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцэтгэлийн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагчид өгээдээ харват бүс, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний дуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эвсэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотгоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эвсэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа болон материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АЛБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлэн гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эвсэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эвсэл чийлээд уг санхүүгийн тайланд үндэслэл гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭГЧ



Ш.МӨНХБАЯР

009070023

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	50,448,159.00	5,000,000.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
	Нийт хөрөнгийн дүн	50,448,159.00	5,000,000.00
	Нийт өр төлбөрийн дүн	50,448,159.00	5,000,000.00
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	-	-
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	50,448,159.00	5,000,000.00
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	434,813,866.00	566,187,257.00
	Үйл ажиллагааны зардлын дүн	434,813,866.00	566,187,257.00
	Үйл ажиллагааны үр дүн	434,813,866.00	566,187,257.00
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-	-
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	-	-
	Эцсийн үлдэгдэл	-	-
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	434,546,716.00	566,187,257.00
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	-	-
	Үйл ажиллагааны ЦМГ	434,546,716.00	566,187,257.00
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(434,546,716.00)	(566,187,257.00)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	685,296,000.00	566,187,257.00
	Урсгал зардал		
	Хөрөнгийн зардал	685,096,000.00	566,187,257.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	685,096,000.00	566,187,257.00
	Улсын төсвөөс санхүүжих		
	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	634,647,800.00	515,739,057.00
	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	50,448,200.00	50,448,200.00

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан сумын ОНХС нь Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан иргэдийн аюулгүй амьдрах орчныг сайжруулах, эрүүл идэвхтэй амьдралыг дэмжих, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, соёл урлаг, боловсролын байгууллагын үйл ажиллагааг дэмжих, авто замыг засварлан шинэчлэх, хатуу хучилттай авто зам шинээр барих, тохилог орчин эко хорооллыг бий болгох зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлдэг байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Дөрөв. Аудитын гол асуудал

Дархан сумын ОНХС-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн 6 дугаар зүйлд заасантай, тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа мэргэжлийн холбоодын төлөөллийг оролцуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасантай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 646.8 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, санхүүгийн үр дүнгийн болон мөнгөн гүйлгээний тайлангийн өмнөх оны дүнг 353.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснийг залруулж, хийгдээгүй ажлын хөлс 5.0 сая төгрөгийг тайлант үеийн зардлаар бүртгэснийг авлагын дансанд тус тус залруулж, 288.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Сумын ОНХС-ийн хөрөнгийг төлөвлөж батлуулахдаа Цагдаагийн газрын зоорийн давхрын 14.0 сая төгрөгийн засварын ажлыг 2 төсөл, арга хэмжээнд хувааж, гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлсэн байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу ижил төрлийн бараа, ажил, үйлчилгээг нэгтгэн төлөвлөж, батлуулах

2. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулсан эсэхийг шалгахад “Сайжруулсан шороон зам засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулаагүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

- Тендер сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4-т заасан бүрэлдэхүүнийг оролцуулан томилж байх

3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т заасан мэдээллийг 1, 5 сард, 6.1.6, 6.3.6, 6.3.7, 6.4.1-д заасан мэдээллүүдийг 5 сард, 6.4.4-т заасан мэдээллийг 3, 5, 7 сард тус тус хугацаа хоцроож мэдээлсэн. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.4-т заасан нийт 274.1 сая төгрөгийн 2 мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулаагүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

- Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулж байх

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

(сая төгрөгөөр)

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	5	646.8	2	358.7	-	-	-	-	3	288.1
2	Төсөл, хөтөлбөр	-	-	-	-	-	-	-	-	-	-
3	ЗГТС	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	ТТЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	ТЕЗ	-	-	-	-	-	-	-	-	-	-
	НИЙТ	5	646.8	2	358.7	-	-	-	-	3	288.1